

Стандарт

СЗ – Тээврийн хэрэгсэл ба жолоодлого

2015 оны 1-р сар

Группийн Стандарт	Гарчиг: Тээврийн хэрэгсэл ба жолоодлого		Баримт бичгийн №: ЭМААБООН-В-15	
	Үйл ажиллагаа: Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Орон нутаг (ЭМААБООН)			
	Хуудасны тоо: 4			
	Гүйцэтгэх хороо баталсан огноо: 2015 оны нэгдүгээр сарын 21	Хүчин төгөлдөр болох огноо: 2015 оны долдугаар сарын 1	Дараахийг орлоно: СЗ – Тээврийн хэрэгсэл ба жолоодлого (2008)	Доорх огнооноос өмнө хяналт шалгалт хийхгүй: 2016 оны долдугаар сарын 1
Эзэмшигч: Группийн Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Орон нутаг хариуцсан захирал		Батлагч: Гүйцэтгэх хороо		Хэнд зориулах: Рио Тинтогийн бүх ажилтан, Рио Тинто Группийн салбар компани, хэлтэс, нэгж бүрт
Бусад бодлого, стандарт, журам, удирдамжтай шууд холбогдох байдал: Рио Тинтогийн удирдлагын тогтолцооны стандарт, Группийн хэмжээнд мөрдөх Дугуй ба обудын журам, СЗ – Тээврийн хэрэгсэл ба жолоодлогын зааварчилгаа.				
Баримт бичгийн зорилго : Группийн Аюулгүй ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох. Рио Тинтогийн үндсэн болон гэрээт ажилтнууд, Рио Тинтогийн салбар нэгж дээр болон ажлын зорилгоор салбар нэгжээс гадуур ашиглаж буй тээврийн хэрэгсэл, далд уурхайн болон гадаргын хүнд машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглах, ажиллуулах үедээ осол гэмтэл авах, амь насаа алдахаас сэргийлэх наад захын шаардлагуудыг тодорхойлно.				

C3 – Тээврийн хэрэгсэл ба жолоодлого

Хамрах хүрээ ба зорилго

Уг стандарт нь Рио Тинто группийн бизнесийн бүх нэгж, удирдлага дах үйлдвэр, хайгуул судалгааны үе шатнаас уурхайн хаалт хүртэлх үйл ажиллагааны бүх үе шатанд ажиллаж буй үндсэн ба гэрээт ажилтнуудад хамааралтай.

Энэхүү стандарт нь Рио Тинто болон түүний гүйцэтгэгч нарын эзэмшлийн болон ашиглаж буй тээврийн хэрэгслийг Рио Тинтогийн салбар нэгж дээр болон ажлын зорилгоор Рио Тинтогийн салбар нэгжээс гадуур ашиглахад хамаарна.

Энэхүү стандартын зорилго нь дараах тохиолдлоос үүдэлтэйгээр хүн бэртэл гэмтэл авах, амь насаа алдахаас сэргийлэхэд оршино. Үүнд:

- тээврийн хэрэгсэл хоорондын,
- явган зорчигч ба тээврийн хэрэгсэл хоорондын;
- нэг тээврийн хэрэгслээс үүдсэн осол, зөрчил багтана.

Хяналт тавих шаардлага

Энэхүү стандартаар тавьсан шаардлагыг Рио Тинтогийн удирдлагын тогтолцоонд тодорхойлсон аливаа шаардлага дээр нэмж дагаж мөрдөнө. Эрсдэлийг арилгах нь ямагт эн тэргүүнд байна.

Төлөвлөлт

Эрсдэлийн үнэлгээ

- 1.1 Тээврийн хэрэгслийн төрөл болгонд тухайн тээврийн хэрэгслийн ашиглалт, засвар үйлчилгээний бүх талыг хамарсан эрсдэлийн үнэлгээг холбогдох оператор, засварчны оролцоотойгоор хийсэн байх ёстой.
- 1.2 Ажил үйлчилгээний шаардлага хангахуйц байлгах үүднээс бүх тээврийн хэрэгсэлд засвар үйлчилгээний тогтсон хуваарийн дагуу засвар үйлчилгээ хийнэ.
- 1.3 Бүх тээврийн хэрэгсэлд ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шалтгалт хийж байх шаардлагатай. Ажил эхлэхийн өмнөх аюулгүй ажиллагааны шалгалтын давтамж, хамрах хүрээг эрсдэлийн үнэлгээгээр тогтооно.

Хэрэгжүүлэлт ба ашиглалт

Замын хөдөлгөөний менежмент

- 1.4 Салбар нэгж бүр батлагдсан замын хөдөлгөөний төлөвлөгөөтэй байна.
- 1.5 Тээврийн хэрэгсэл хоорондын, тээврийн хэрэгсэл ба явган зорчигч хоорондын, мөн тээврийн хэрэгсэл ба төмөр замын үйл ажиллагаанаас үүдэж болзошгүй эрсдэлийг тодорхойлохын тулд тээврийн хэрэгсэл ашиглан

гүйцэтгэх бүх үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагатай ба мөргөлдөх, шүргэлцэхээс сэргийлэх хяналтын арга хэмжээ авна.

- 1.6 Ил уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг салбар нэгж бүрт ил уурхайн орчимд мөрдөх дараахшаардлагыг тогтоосон байна:
- a) хүнд даацын машин механизмын оператортой урьдчилан холбоо тогтоож, ойлголцолгүйгээр аливаа тээврийн хэрэгсэл хүнд даацын машин механизмд 50 м-ээс дотогш ойртохгүй байх,
 - b) уурхайн талбай дээр гүйцэж түрүүлэх үйлдлийг зөвшөөрдөг бол хүнд даацын машин механизмыг гүйцэтгэж түрүүлэхдээ урьдчилан холбоо тогтоох ёстой.
- 1.7 Далд уурхайд хүнд даацын машин механизмын оператортой урьдчилан холбоо тогтоож, ойлголцолгүйгээр аливаа хүн, тээврийн хэрэгсэл хүнд даацын машин механизмд ойртож үл болно.

Аяллын удирдлага

- 1.8 Салбар нэгж бүр эрсдэлд суурилсан аяллын менежментийн журам боловсруулж, дагаж мөрдөх ёстой.

Ачаа тээвэрлэх

- 1.9 Уурхайн талбай руу болон уурхайн талбайгаас тээвэрлэх, эсвэл тээвэрлэж буй аливаа ачааг ачих буюу буулгахын өмнө дараах нөхцөл байдал үүсэхээс сэргийлэх зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийх ёстой. Үүнд:
- a) бэхэлгээг суллах үед ачаа гулсах, өнхрөх, хөмрөх, унах, хөдлөхөөс сэргийлэх,
 - b) буулгахаас өмнө ачаа хөдлөхөөс сэргийлэх,
 - c) химийн бодис асгарах, химийн эрчим хүч ялгарахаас сэргийлэх.
- 1.10 Ачааг бэхлэхдээ ачаанд хуримтлагдсан потенциал энергийг хяналттайгаар суллах боломж бүхий бэхэлгээ ашиглах шаардлагатай.

Тээврийн хэрэгсэл

- 1.11 Шинээр авах бүх төрлийн хөнгөн тэрэг нь аюулгүй ажиллагааны дараах системтэй байх ёстой. Үүнд:
- a) тогтворжуулах систем,
 - b) үл түгжигдэх тоормосны систем,
 - c) урьдчилан чангалах үйлдэлтэй, гурван цэгт бэхэлгээ бүхий суудлын даруулга,
 - d) хажуугийн, хөшигний болон урд талын, ослын дэр.

Энэхүү заалтын зарим шаардлагууд нь сэрээт ачигч ба далд уурхайд ашиглах хөнгөн тэргэнд хамаарахгүй байж болно.

- 1.12 Ажлын зорилгоор ашиглаж байгаа бүх тээврийн хэрэгсэл нь:

- a) талбайн менежерийн баталсан эрсдэлийн үнэлгээнд өөрөөр заагаагүй бол жолооч болон зорчигч тус бүрт зориулсан байнгын суудал, аюулгүйн бүстэй байх,
 - b) хурдны хамгийн доод хязгаараас хэтрэх хүчин чадалтай тээврийн хэрэгсэл бүр хурд хэмжигчтэй эсвэл тээврийн хэрэгслийн хурдыг операторт мэдээлэх түүнтэй адилтгах өөр бусад хэрэгсэлтэй байх,
 - c) явган зорчигч ба бусад биеттэй санамсаргүй мөргөлдөхөөс сэргийлсэн анхааруулах хэрэгсэлтэй байх ёстой.
- 1.13 Аюулгүйн бүстэй бол жолооч болон бүх зорчигч аюулгүйн бүсээ байнга зүүх ёстой.
- 1.14 Тээврийн хэрэгсэл жолоодож байхдаа жолооч нь гар чөлөөтэй байх эсэхээс үл хамааран гар утас болон бусад зөөврийн электрон төхөөрөмж ашиглахыг хориглох бөгөөд зөвхөн тээврийн хэрэгслийг зогсоосон, аюулгүй газар байрлуулсан үед ашиглахыг зөвшөөрнө..
- 1.15 Радио холбоо ашиглах бол дараах шаардлага тавигдана. Үүнд:
- a) жолоочийн анхаарлыг сарниулахгүй, тээврийн хэрэгслийг жолоодох ажилд анхаарлаа төвлөрүүлэх боломжтой байхаар байрлуулах,
 - b) дүрэм журмын дагуу ашиглах.
- 1.16 Эрсдэлд суурилсан аргачлалын дагуу тоормосны системийн ажиллагааг тогтмол шалгана.
- 1.17 Чирэх зориулалтгүй тээврийн хэрэгслээр тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг чирэхийг хориглоно.

Дугуй болон обудны аюулгүй ажиллагаа

- 1.18 Дугуйны засвар үйлчилгээ хийх, дугуй шатах үед шуурхай арга хэмжээ авахболон мэргэжлийн ур чадварыг тодорхойлох журамтай байх ёстой. Мэргэжлийн ур чадварыг тодорхойлох журамд гэрчилгээний хүчинтэй хугацааг тусгайлан заасан байх бөгөөд гурван жилээс илүүгүй байх ёстой.
- 1.19 Үйл ажиллагаа бүрт дараах шаардлагыг хангасан хүнд машин механизм дээр хэрэглэх дугуй, обудад зориулж дугуйны менежментийн төлөвлөгөөг гаргах ёстой:
- a) 2 жилээс доошгүй хугацаанд бие даасан зохих ур чадвар бүхий хүн эсвэл бүлгээр аудит хийлгэж, хянуулсан,
 - b) Группын хэмжээнд мөрдөх дугуй, дугуйн обудын журамд нийцсэн.

Ур чадвар

- 1.20 Тээврийн хэрэгслийг жолоодох, ажиллуулах шаардлагатай хүн бүр тухайн төрлийн тээврийн хэрэгслийг ажиллуулах ур чадвартай, зөвшөөрөлтэй байх ёстой.

- 1.21 Тээврийн хэрэгсэл, хөдөлгөөнт тоног төхөөрөмжийн төрөл тус бүрт тохируулж хийсэн эрсдэлийн үнэлгээгээр тогтоосон хугацаанд жолоочийн мэргэжлийн ур чадварыг дахин үнэлж байх ёстой.
- 1.22 Ил уурхайн үйл ажиллагааны үед дараах шаардлагуудыг тусгасан журам боловсруулж, дагаж мөрдөх ёстой. Үүнд:
- a) ил уурхайн орчимд машин жолоо барих хүний тоог хязгаарлах,
 - b) 2 долоо хоног эсвэл эрсдэлийн үнэлгээнд тусгайлан заасан бол түүнээс бага хугацаагаар ил уурхайг орхиж явсан хүмүүст уг хугацаанд ил уурхай дээр ямар өөрчлөлт гарсныг танилцуулж байх.